



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 637

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Жижиг дунд үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 31 нэрийн, нийт 18,936,889.18 (арван найман сая есөн зуун гучин зургаан мянга найман зуун наян есөн төгрөг арван найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Жижиг дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө акталж данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

123006673

32-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дүгээр сарын 20 ны өдрийн
637 дугаар тогтоолын хавсралт

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн балансын үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ, Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	HP- CP-1025 өнгөт принтер	2016-11-16	1	650,000.00	650,000.00
2	Дэлгэц дейл led H2414H	2016-05-12	1	419,900.00	419,900.00
3	Компьютер	2014-10-31	1	1,050,000.00	1,050,000.00
4	Компьютер Acer	2015-04-	1	1,330,800.00	1,330,800.00
5	Компьютер Dell	1/1/2018	1	1,638,890.00	1,638,890.00
6	Компьютер дейл дэлгэцтэй	2018-07-01	1	1,638,890.00	1,638,890.00
7	Принтер 3 үйлдэл	10/1/2013	1	373,890.00	373,890.00
8	Тог баригч	2017-12-28	1	125,290.00	125,290.00
9	Тог баригч	2018-01-01	1	125,290.00	125,290.00
10	Тэжээлийн блок pro902ws	2017-12-28	1	949,900.00	949,900.00
11	Цагаан дэлгэц	2014-10-31	1	582,600.00	582,600.00
12	Тог баригч	2018-01-01	1	125,290.00	125,290.00
13	Тог баригч.	2016-06-27	1	250,181.18	250,181.18
14	Хөргөгч	2014-11-06	1	479,990.00	479,990.00
15	Халаагуур /тень/	2015-05-11	2	64,999.00	129,998.00
16	Халаагуур тень keyon	2016-12-28	1	114,800.00	114,800.00
17	Тог баригч	2018-01-01	1	125,290.00	125,290.00
18	Ерson сканнер	2015-12-16	1	3,499,900.00	3,499,900.00
19	530 торон хар сандал никель	2016-11-21	1	165,000.00	165,000.00
20	Мэдээллийн самбар	2010-03-13	2	150,000.00	300,000.00
21	Сандал	2011-12-06	1	109,000.00	109,000.00
22	Сандал	2012-11-05	1	361,900.00	361,900.00
23	Сандал /үзэсгэлэнгийн/	2016-05-20	200	15,000.00	3,000,000.00
24	Сандал MCUR	2011-07-01	1	64,900.00	64,900.00
25	Сандал MCUR	2008-12-31	1	64,900.00	64,900.00
26	Сейф/ саарал/	2011-06-17	1	159,990.00	159,990.00
27	Тумбочка /шинэ/	2012-11-05	1	82,500.00	82,500.00
28	Сандал	12/6/2011	1	109,000.00	109,000.00
29	Шкаф бичгийн	2015-12-31	1	300,000.00	300,000.00
30	Төмөр шүүгээ	2015-08-19	1	290,900.00	290,900.00
31	Сандал	11/5/2012	1	317,900.00	317,900.00
НИЙТ ДҮН			232	15,736,890.18	18,936,889.18
					(арван найман сая есөн зуун гучин зургаан мянга найман зуун наян есөн төгрөг арван найман мөнгө)